



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/199/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Пийк Ом Аудит” ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН 4 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.БАЯРЖАРГАЛ ТАНАА

2025.02.25 № СЭА-2026/199/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/228 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 17,402.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б.Батмөнх* Б.БАТМӨНХ



Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	121,989,656.99	13,128,242.10
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		121,989,656.99	13,128,242.10
31210	Төгрөг		121,989,656.99	13,128,242.10
31211	Төрийн сангийн харилцах		121,989,656.99	13,128,242.10
35	Бараа материал	5	129,881,462.60	150,570,227.60
35100	Түүхий эд материал		-	27,620,900.00
35110	Тусгай зориулалттай материал		-	27,620,900.00
35400	Хангамжийн материал		129,881,462.60	122,949,327.60
35410	Бичиг хэргийн материал		2,989,640.00	215,000.00
35420	Аж ахуйн материал		125,410,552.60	122,703,445.60
35460	Хүнсний материал		679,770.00	30,882.00
35470	Бусад хангамжийн материал		801,500.00	-
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН			
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,154,242,810.82	1,129,559,130.24
392	Биет хөрөнгө		1,103,230,810.82	1,078,391,380.25
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,234,606,149.00	1,234,606,149.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(311,928,631.18)	(332,505,400.42)
39204	Хуримтлагдсан элэгдэл			
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		153,697,866.00	170,999,456.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(61,553,368.02)	(84,147,900.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		82,591,173.16	104,382,173.16
39208	Хуримтлагдсан элэгдэл		(53,196,406.76)	(61,634,063.19)
39209	Зам, гүүрийн байгууламж		882,240.00	882,240.00
39210	Хуримтлагдсан элэгдэл		(422,740.23)	(510,964.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө		67,096,550.00	67,096,550.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(10,928,892.15)	(23,761,730.75)
39217	Ном		2,386,871.00	2,984,871.00
393	Биет бус хөрөнгө		51,012,000.00	51,167,749.99
39301	Программ хангамж		2,021,100.00	2,199,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(2,021,100.00)	(2,043,350.01)
39303	Бусад биет бус хөрөнгө		51,012,000.00	51,012,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН			
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,406,113,930.41	1,293,257,599.94
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	222,600.00	3,737,330.00
413	Өглөг		222,600.00	3,737,330.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		222,600.00	3,737,330.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг			
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		222,600.00	3,737,330.00
51	Засгийн газрын хувь оролцоо		1,405,891,330.41	1,289,520,269.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		318,281,669.42	318,281,669.42
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		318,281,669.42	318,281,669.42
512	Хуримтлагдсан үр дүн		794,323,790.72	677,952,730.25
5121	Өмнөх үеийн үр дүн		695,606,520.22	794,323,790.72
5122	Тайлант үеийн үр дүн		98,717,270.50	(116,371,060.47)

513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		293,285,870.27	293,285,870.27
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,405,891,330.41	1,289,520,269.94
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,406,113,930.41	1,293,257,599.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	1,310,102,270.94	1,368,446,154.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		110,236,152.94	1,368,446,154.59
120	Нийтлэг татварын бус орлого		110,236,152.94	88,385,090.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		3,645,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,645,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		80,805,173.00	37,792,690.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		25,785,979.94	50,592,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\ут\		-	1,127,985,200.00
122112	Урсгал санхүүжилтийн орлого\он \		135,962,618.00	152,075,864.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,063,903,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,063,903,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,063,903,500.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2	1,211,385,000.44	1,484,817,215.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,211,385,000.44	1,484,817,215.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,075,422,382.44	1,321,429,750.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		780,990,950.25	940,904,225.89
210101	Үндсэн цалин		537,045,823.64	599,627,605.82
210102	Нэмэгдэл		205,536,377.31	278,054,347.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-	27,254,409.11
210104	Урамшуулал		38,408,749.30	35,967,863.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		95,975,583.32	117,254,799.00

210201	Тэтгэврийн даатгалын зардал		66,406,312.58	79,528,699.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал		7,906,673.94	9,431,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал		4,183,631.80	4,715,700.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		3,495,793.26	4,715,700.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал		13,983,171.74	18,863,100.00
210301	Гэрэл, цахилгаан		7,854,210.00	10,431,091.59
210302	Түлш, халаалт		96,806,803.00	95,807,703.00
210303	Цэвэр, бохир ус		12,302,190.00	25,853,620.00
210604	Урсгал засвар		18,999,415.00	19,983,450.00
2105	Нормативт зардал		117,290,260.00	127,680,818.00
210502	Хоол, хүнс		117,290,260.00	127,680,818.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,798,500.00	4,251,790.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,798,500.00	4,251,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		79,367,088.87	131,338,117.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		34,914,850.00	43,121,747.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,919,604.00	23,664,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		42,532,634.87	64,552,270.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		-	11,311,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		-	11,311,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		98,717,270.50	(116,371,060.47)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		98,717,270.50	(116,371,060.47)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,310,102,270.94	1,368,446,154.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	110,236,152.94	1,368,446,154.59
120	Нийтлэг татварын бус орлого	110,236,152.94	88,385,090.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,645,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,645,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	80,805,173.00	37,792,690.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	25,785,979.94	50,592,400.00
122	Тусламжийн орлого	-	1,127,985,200.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,127,985,200.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,127,985,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\ут\	-	1,127,985,200.00
122112	Урсгал санхүүжилтийн орлого\он \	135,962,618.00	152,075,864.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,063,903,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,063,903,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,063,903,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,186,033,435.57	1,388,922,479.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,050,070,817.57	1,388,922,479.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,030,724,517.57	1,377,610,879.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	780,990,950.25	940,904,225.89
210101	Үндсэн цалин	537,647,518.29	599,627,605.82
210102	Нэмэгдэл	204,934,682.66	278,054,347.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,254,409.11
210104	Урамшуулал	38,408,749.30	35,967,863.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,975,583.32	117,254,799.00
210201	Тэтгэврийн даатгал	66,089,098.74	79,528,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,829,542.31	9,431,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,919,664.00	4,715,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,809,314.84	4,715,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,327,963.43	18,863,099.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210301	Гэрэл, цахилгаан	7,854,210.00	10,431,091.59
210302	Түлш, халаалт	96,806,803.00	95,807,703.00
210303	Цэвэр, бохир ус	12,302,190.00	25,853,620.00
210604	Урсгал засвар	18,999,415.00	19,983,450.00
2105	Нормативт зардал	118,089,230.00	123,517,200.00
210502	Хоол, хүнс	118,089,230.00	123,517,200.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,468,500.00	4,429,790.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,468,500.00	4,429,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,200,254.00	39,429,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,438,560.00	30,240,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,761,694.00	9,188,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,346,300.00	11,311,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,346,300.00	11,311,600.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,346,300.00	11,311,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,477,682.43	(108,861,414.89)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,086,540.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,086,540.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	8,086,540.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,086,540.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,086,540.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,391,142.43	(108,861,414.89)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	112,598,514.56	121,989,656.99
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	121,989,656.99	13,128,242.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	794,323,790.72	1,405,891,330.41
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	794,323,790.72	1,405,891,330.41
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн	-	-	(116,371,060.47)	(116,371,060.47)
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	318,281,669.42	293,285,870.27	677,952,730.25	1,289,520,269.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,281,114,464.59	1,280,061,064.59	1,053,400.0	99.9
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,129,038,600.00	1,127,985,200.00	1,053,400.0	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих				
122006	Төсвөөс санхүүжих ОН	152,075,864.59	152,075,864.59	-	100.0
12	Татварын бус орлого	1,129,038,600.00	1,127,985,200.00	1,053,400.0	99.9
122	Тусламжийн орлого	1,129,038,600.00	1,127,985,200.00	1,053,400.0	99.9
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
132001	Орон нутгийн төсвөөс				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)				
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,240,179,700.00	1,236,846,614.89	3,333,085.1	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,228,868,100.00	1,225,535,014.89	3,333,085.1	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	943,155,400.00	940,904,225.89	2,251,174.1	99.8
210101	Үндсэн цалин	628,823,200.00	599,627,605.82	29,195,594.2	95.4

210102	Нэмэгдэл	285,931,000.00	278,054,347.49	7,876,652.5	97.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,254,409.11	(27,254,409.1)	
210104	Урамшуулал	28,401,200.00	35,967,863.47	(7,566,663.5)	126.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,254,800.00	117,254,799.00	1.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	79,528,700.00	79,528,700.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,431,600.00	9,431,600.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,715,700.00	4,715,700.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,715,700.00	4,715,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	18,863,100.00	18,863,099.00	1.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
210301	Гэрэл, цахилгаан	10,431,091.59	10,431,091.59	-	100.0
210302	Түлш, халаалт	95,807,703.00	95,807,703.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	25,853,620.00	25,853,620.00	-	100.0
210604	Урсгал засвар	19,983,450.00	19,983,450.00	-	100.0
2105	Нормативт зардал	124,570,600.00	123,517,200.00	1,053,400.0	99.2
210502	Хоол, хүнс	124,570,600.00	123,517,200.00	1,053,400.0	99.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал				
210604	Урсгал засвар				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,452,000.00	4,429,790.00	22,210.0	99.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,452,000.00	4,429,790.00	22,210.0	99.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,435,300.00	39,429,000.00	6,300.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,246,800.00	30,240,600.00	6,200.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,188,500.00	9,188,400.00	100.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,311,600.00	11,311,600.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,311,600.00	11,311,600.00	-	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,311,600.00	11,311,600.00	-	100.0
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,392,255,564.59	1,388,922,479.48	3,333,085.1	99.8
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(111,141,100.00)	(108,861,414.89)	(2,279,685.1)	97.9
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	111,141,100.00	108,861,414.89	2,279,685.1	97.9
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	111,141,100.00	108,861,414.89	2,279,685.1	97.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	121,989,656.99	(121,989,657.0)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	13,128,242.10	(13,128,242.1)	

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 34,298.9 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар материаллаг зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн болно

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн бүртгэлд 34,298.9 мянган төгрөгийн өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй, 52 ширхэг үндсэн хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалт болон УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө” стандарт болон “Толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланг залруулга хийж, цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлж байх зөвлөмж хүргүүлээ.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж шийдвэрлээгүй	1	34,298.9					1	34,298.9				
Дүн	1	34,298.9					1	34,298.9				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			